



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-34
<hr/>	
1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	27-25
2.“Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхий аудиторос 2023.06.29-ний өдөр ирүүлсэн/	25-28
3.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	28-29
4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	29-33

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 07 дугаар сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Амартүвшин;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Баделхан, С.Ганбаатар, Б.Жавхлан, С.Одонтуяа.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Засгийн газраас 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахаар тогтов.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн Засгийн газраас 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг, мөн өдөр өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахаар тогтов.

Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Ч.Сарантуяа нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, О.Цогтгэрэл, Ш.Раднаасэд нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхий аудитороос 2023.06.29-ний өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга С.Цэрэнбаяр, мөн газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Захиргаа, хууль, эрх зүйн газрын ерөнхий санхүүч П.Батцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын

хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Ч.Сарантуяа нар байлцав.

Тогтоолын төслийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний” гэснийг “2023 оны 08 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэмүүлэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерөн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газраас эрх зүйн дүгнэлт ирээгүй байгаа тул хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн
Чингис хаан” танхим 11 цаг 05 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая. Юуны түрүүнд та бүхэнд Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Жигжидийн Батжаргал гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Лхавгийн Мөнхбаатар гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Шатарбалын Раднаасэд гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд Төсвийн байнгын хорооны 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогт тогтоолын төсөл, Засгийн газар 2023 оны 6 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг байгаа.

Ингээд санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэх энэ асуудал байна.

Хоёр дахь нь Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох

тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, төрийн аудитын байгууллагаас бас оруулж ирсэн асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Гараа өргөө. Кнопоо дараарай. Чойжилсүрэн гишүүнээр тасалъя. Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны дарга, гишүүддээ өглөөний амгаланг айлтгая.

Засгийн газраас өргөн барьсан Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хууль байгаа юм. Ганцхан заалттай. Нөгөө эрүүл мэндийн санхүүжилттэй холбоотой юм. Тийм учраас тэр хуулийг нөгөө ганцхан заалттай хууль учраас анхны хэлэлцүүлгийг өнөөдрийн хурлаар хийчихвэл яасан юм бэ гэж бодож байна. Тийм учраас би ямар санал гаргах гэж байгаа вэ гэхээр Төсвийн тухай хуульд оруулах өөрчлөлтийн анхны хэлэлцүүлгийг өнөөдрийн Байнгын хорооны хурлаар явуулъя гэсэн ийм горимын санал гаргаж байна. Та бүхэн дэмжээд өгөөрэй, баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн дарга хэлэлцэх асуудлын дараалалд асуудал нэмэх санал гаргаж байна. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай анхны хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хорооны хуралдаанаар өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулъя гэсэн саналыг бас гаргаж байна. Ингээд Тогтохсүрэн гишүүний гаргасан саналаар санал хураалтыг явуулъя. Дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах санал хураалт байна уу? 58.3 хувиар дэмжигдлээ. Ингээд хэлэлцэх асуудлын дараалалд оруулахаар боллоо. Дараачийн санал гаргасан гишүүн Чойжилсүрэн гишүүн байсан. Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амрыг эрье ээ. Тэмүүлэн дарга аа 2 асуудал хэлэлцүүлэх гэсэн юм. Өнгөрсөн 7 хоногийн нэг дэх өдөр бид нар хэлэлцүүлэгт явж байгаад хууль зүйн дүгнэлт гаргана гэдэг асуудлаар 2 хуулийн төслийг хойшлуулсан байгаа. Эхнийх нь ямар нэгэн Гаалийн тариф гаалийн тарифын тухай хууль ямар нэгэн асуудал байхгүй. Энэ хуулийг 1 дүгээрт хэлэлцүүлж өгөөч гэж, 2 дугаар хууль нь ААН-ийн орлогын албан татварт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ингээд дүгнэлт нь гарчхаад ирж байгаа юм байна. Хэлэлцээд хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж өгөөч гэсэн ийм хүсэлт байна. Энэ 7 хоногийн хэлэлцэх асуудлын хүрээнд санал хураах шаардлагагүйгээр суучихсан байгаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Өнгөрсөн нэг дэх өдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр хойшлуулсан 2 асуудал байгаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нөгөөх нь Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. Тэгээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал дээр хууль зүйн дүгнэлт гаргуулах шийдвэрийг бас Байнгын хорооноос гаргасан. Одоогоор эрх зүйн дүгнэлт нь ирээгүй байгаа учраас 2 асуудлын хэлэлцэх асуудлыг нь шийдээд явъя, нөхцөлтэйгөөр. Тэгээд гаалийн тариф болоод Гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал ямар нэг асуудалгүй учраас хэлэлцээд явж байя. Амжаад сая ирэх зүйн дүгнэлт нь ирсэн тохиолдолд нөгөө хуулийг нь бас хэлэлцээд явъя л гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Ингээд Чойжилсүрэн гишүүний гаргасан саналыг дэмжиж хэлэлцэх асуудлын дараалалд оруулъя гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

Санал хураалт

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ. Ингээд хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулахаар тусгахаар боллоо.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээр асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан сайд хийхээр байгаа. Чойжилсүрэн сайд танилцуулгыг хийе ээ.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17.1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18.1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч төлөвлөгдсөн дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн

нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Сангийн сайд болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын багцын нийт 242 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно. Нэгдсэн төсвийн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2.9 их наяд төгрөгийн гүйцэтгэл гарч урсгал зардал 1.7 их наяд төгрөг, хөрөнгийн зардалд 1.2 их наяд төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 99.2 хувь буюу 2 их наяд 942.8 тэрбум төгрөгийг Сангийн сайд, 0.8 хувь буюу 24.4 тэрбум төгрөгийг Монгол Улсын ерөнхий аудиторовын төсвийн багцын зарлага эзэлж байна. Улсын төсвөөс 1 их наяд 598.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол гадаадын төслийн зээлийн 1 их наяд 280.1 тэрбум төгрөг, тусламжийг нь 295.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг авч ашигласан байна.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулга аудитын дүгнэлтүүдтэй танилцаж Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайдад баярлалаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат дарга танилцуулна.

Занданбат даргын микрофоныг өгье 4 номер.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Сангийн сайдын эрх эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 239 тайлан нэгтгэгдсэнээс 115 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж нэг байгууллага аудитад хамрагдаагүй. 123 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй. Харьяа 104 байгууллагад өөрчлөлтгүй, 10 байгууллагад хязгаарлалттай, нэг байгууллагад сөрөг дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 153.7 тэрбум төгрөгийн 231 зөрчил илэрснээс 80 сая төгрөгийн 33 төлбөрийн акт тогтоож 136.9 тэрбум төгрөгийн 75 албан шаардлага хүргүүлж, 9.1 тэрбум төгрөгийн 119 зөвлөмж өгч 7.6 тэрбум төгрөгийн 4 хариуцлага тооцоулах албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй нийт 0.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 11 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 592.8 тэрбум төгрөгийн 161 алдаа илэрснээс аудитын явцад 592.6 тэрбум төгрөгийн 147 алдааг залруулж 0.2 тэрбум төгрөгийн алдааг

дахин давтан гаргахгүй байх 14 зөвлөмж өглөө. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 237.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 77.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс шилжин хэрэгжих 162.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2, шинээр хэрэгжих 75 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээ байна.

Төсөл арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 72 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 87 хувьтай байна. Тус байнгын хороо Аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулахыг зөвлөж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр. Хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт хүрэх түвшин тодорхойгүйгээс төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна.

Төсөл арга хэмжээний гүйцэтгэл хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна. Төсөл хөтөлбөрийн шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах төсөвт ачаалал үүсгэж жил бүрийн аудитаар өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байна. Харьяа төсвийн захирагчдын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатай байна. Гадаад

дотоодын зээлийн эх үүсвэр болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөс иргэн хуулийн этгээдэд олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд байршуулаагүйгээс хэд хэдэн эх үүсвэрээс давхардуулан зээл аван, зээлийн баталгаа чанаргүй болж гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй зээлийн эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэл нэмэгдэж байна. Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцууллаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Занданбат даргад баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн алба үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ядамын Самбууням Үндэсний Аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга, Батжаргалын Заяабал Үндэсний Татварын ерөнхий газрын дарга, Содномцэрэнгийн Цэрэнбаяр Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, Пүрэвдоржийн Батцэцэг Үндэсний Аудитын газрын санхүүгийн менежер, Чойжилсүрэнгийн Тавинжил Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга,

Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалт газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Байгалмаагийн Одонтуяа Сангийн яамны Санхүүгийн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чамбайн Цацрал Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Төмөрбаатарын Мөнгөнцэцэг Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Лхагвадоржийн Эрдэнэбадрах Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Янжингийн Эрдэнэчимэг ГЕГ-ын Тариф татварын газрын дарга. Ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аудитын тайлантай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? нэрсээ өгье.

Раднаасэд гишүүнээр тасалъя. Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Аудитын дүгнэлт бас энэ сүүлийн 2 жилийн дүгнэлт яах вэ урьд урьдынхаас хамаагүй илүү сайн гардаг болсон. Би тэрэн дээр бас яг энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргын хувьд бас үнэлж байгаа. Тэгэхээр одоо энэ аудитынхан дүгнэлтээ гаргадаг зөрчилтэй олон байгууллагууд байдаг. Гэтэл харамсалтай нь аудитын

байгууллага нөгөө дээд талын Ерөнхий сайд ч юм уу аль эсвэл харьяалах яамны сайд ч юм уу тэд нарт нь ингээж хариуцлага тооц гэж албан бичиг явуулдаг. Харамсалтай нь тэрнийх нь дагуу ерөөсөө шийдвэр гардаггүй нэг шүдгүй арслан шиг болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ аудитын дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ 1 цагаас бас хэлэлцэж ярилцана. Тэгээд тэр үеэрээ нэг зүйлийг тодорхой болгоод бэлэн болгоорой. Өөрөөр хэлбэл төсвийн Ерөнхийлөгчийн захирагч нар зөрчилтэй дүгнэлт гаргуулсан тэр хүн, тэр албан тушаалтнуудын бүх нэрсийг тэр зөрчилтэй хэдэн төгрөгийн зөрчил гаргасан юм, тэрэнтэй нь яаралтай өгөөрэй. Хэрвээ өгөхгүй бол Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хуралдахгүй ээ гэдгийг бас бүлгийн дарга Тогтохсүрэн даргад хэлчихье.

Тэгэхээр ер нь бол бид нар энэ Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийг бас амилуулах зайлиггүй шаардлага гарчхаж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ Монгол Улс парламентын засаглалтай орон.

Тийм учраас парламентын хяналт шалгалт бол бас энэ тодорхой хэмжээгээр үйлчилдэг тэрний дагуу хариуцлага тооцдог энэ механизмыг нэг сайн ажиллуулж чадахгүй бол бид нар бас энэ гүйцэтгэх засаглал энэ аудиттай нөлөөлдөг юм уу яадаг юм. Аудит нь ч бас шүдгүй арслан хуулиараа шүдгүй арслан шиг байгаа. Тэгээд энэ гүйцэтгэх засаглал дотроо бол нэг тийм найраан дундаа явдаг тэгээд ихэнх нь юу байдаг юм, яамдын удирдлагууд, яамдын сайд нар, удирдлагууд, агентлагийн удирдлагууд бүгдээрээ хэн нэгэн дарга нарын сонгуулиар цүнх барьж байсан нөхдүүд байдаг учраас нэг нэгнийгээ хамгаалдаг ийм зүйл байгаад байна.

Тийм учраас энэ аудитын дүгнэлтийг амилуулах зайлиггүй

шаардлага энэ Их Хурал дээр зайлшгүй гарч байна. Тийм учраас манай Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүд нэг цагаас хуралдана. Тэр хуралдаан дээрээ бид нар бол яг энэ зөрчилтэй дүгнэлт гаргасан тэр албан тушаалтнуудад зайлшгүй хариуцлага тооцуулах тийм асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх ийм зорилготой байгаа гэдгийг хэлье.

Тийм учраас нэг цагийн хуралд бэлтгэлээ хангаарай гэж та бүхэнд хэлье.

Г.Тэмүүлэн: Занданбат дарга хариулах уу? Пүрэвдорж гишүүний асуултад 4 номер.

Д.Занданбат: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Тийм нэгдсэн чуулган дээр бас Их Хурлын даргын хэлсэн чиглэл байгаа. Тэгээд тэр хүрээн дээр энэ судалгааг гаргачихсан байж байна. Ингээд хуралдааны чөлөө заваар би танд хүргээд өгчихье.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурал, Засгийн газар авлигатай тэмцэх чиглэлээр онцгой анхаарал хандуулж холбогдох хууль, эрх зүйн орчин, авлига албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангалах гээд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлах гээд нийтийн ашиг сонирхлын хуульд өөрчлөлт оруулах гээд ингээд маш олон арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч байна. Тэгвэл энэ төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байгаа энэ цаг үед энэ төсөв ард түмний татвар төлөгчдийн мөнгийг захиран зарцуулж байгаа энэ төсвийн ерөнхийлөн болоод төсвийн захирагч нар ерөөсөө энэ гүйцэтгэл юман дээр энэ татвар төлөгчдийн мөнгийг зарцуулалт дээр ерөөсөө ингээд зөрчил дутагдлууд гарсаар байгаа нь өөрөө бас энэний чинь цаана зөрчил дутагдлууд байна гэдэг чинь

өөрөө албан тушаалын гэмт хэргийн шинжтэй зүйлүүд байхыг үгүйсгэхгүй ээ. Эрх мэдлээ урвуулан ашиглах зориулалт бусаар зарцуулах гээд ийм зөрчил юмнууд ямаршухан байна. Энэ бол 2022 онд албан тушаалаа урвуулан хэтрүүлсэн байж болзошгүй хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн акт юм тавьсан. Эдгээрийгээ та бүхэн нэг хэлээдхээч. Тэгээд жил болгон л ингээд л ерөөсөө энэ аудитын байгууллагын энэ төсвийн төлөвлөлт болоод гүйцэтгэл дээр орж ирж байгаа энэ дүгнэлтэд ерөөсөө энэ төсвийн захирагч нар чинь ерөөсөө онцгойлон ач холбогдол өгөхгүй явсаар өнөөдрийг хүрлээ.

Сонсдоггүй, хэрэгжүүлдэггүй, ойшоодоггүй энийг цаашидаа ер нь энэ хяналтын механизмаа яаж сайжруулах юм чангаруулах юм. Ийм байгаад байвал энэ санхүүгийн зөрчил дутагдал чинь гарсаар хэвээр л байна. Тэгээд л жил болгон ийм зөрчил гарлаа, ингээж залруулаа, ийм шаардлага өглөө, акт тавилаа. Ингээд л яваад байх юм уу. Тэгээд энэ чиглэлээр цаашидаа ер нь яах юм бэ гэдгийг нэгд асууя.

2022 онд төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байгаа учраас 2022 он бол бас ковидын бас эдийн засгийн хүндрэл бас дуусаагүй байсан он жилүүд. Тээврээс үүдэлтэй бараа бүтээгдэхүүний үнэ ханшийн өсөлттэй гээд 2022 оны хөрөнгө оруулалт дээр ер нь нэг баахан ёстой нөгөө эхийг нь эцэслэж тугалыг нь тураахгүй гэдэг шиг 2 тэрбумын ажлыг гэхэд нэг 50 сая төгрөг ч юм уу 100 сая төгрөг тавиад л ингээд л орхичихсон юмнууд зөндөө байгаа шүү дээ.

Тэгээд тэрэн дээр нь тендер зарлахад компаниуд орохгүй яаж ч орох вэ дээ. Ер нь нэг 50 сая төгрөгөөр 100 сая төгрөгөөр ямар ажил хийх вэ гээд ийм хөрөнгө оруулалтын ажлууд ер нь хэр байна аа? Тэгээд татагдчихсан. Энийг ер нь цаашидаа яах юм? Нөгөө талаар энэ нөгөө тээврийн асуудлаас болоод бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс болоод

үнийн өөрчлөлттэй хөрөнгө оруулалтын ажлууд байгаа шүү дээ. Төсөв нэмэгдсэн. Одоо энэнтэй холбоотойгоор ер нь ААН-үүдээс санал гомдол юм байгаа юу? Үнийн зөрөөний асуудлыг нэг тодорхой шийдсэн. Бараа бүтээгдэхүүний материалын үнийн өсөлтийг. Төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд байгаа юу?

Ер нь цаашидаа энэ хөрөнгө оруулалтын ажлуудыг ингээд нэг амсуулсан төдий 50, 100 сая төгрөгөөр тавиад ингээд явбал энэ улсын төсөв дээр ер нь тавигдаж байгаа хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл ер нь хэр байх вэ? Энэ жил 2023 онд огт шинэ юм бол байхгүй. Энэ дээр ер нь аудит юу гэж үзэж байгаа вэ? Яах вэ ер нь Төсвийн байнгын хороонд цаашидаа хөрөнгө оруулалтын ажил дээр ер нь 3 жилийн хугацаанд л тухайн төсөвт өртгийг 3 хуваагаад л ер нь 3 жилийн хугацаанд дуусгадаг байя гэдэг л зарчим барьж байгаа шүү дээ. Хэд 10 жил ч үргэлжилж байгаа ажил байна шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд дуусахгүй. Төсөвт өртөг нь 2, 3 дахин нэмэгдчихсэн. Ийм ажлууд ер нь яг одоо улсын төсөв дээр хэд явж байна аа? Хэдий хэмжээний төсөвт өртөгтэй ажлууд явж байна. Энийг хэзээ дуусгах вэ? Сангийн яамныхан. Энэ дээр та бүхэн нэг хариулт өгөөч ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: 4 номер. Занданбат дарга хариулт өгье.

Дээрээс нь нэмээд Сангийн яамныхан нэмэлт тайлбар өгөөрэй.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Аудит жил бүр болгон төсөвт байгууллага төрийн өмчит газруудад санхүүгийн аудит хийж байгаа. Зөрчил бол бас санасныг бодвол бас нэг талдаа гайгүй байгаа боловч бас бодсон хэмжээнд хүрч буурахгүй байгаа. Үүнийг бол аудит сүүлийн 3, 4 жил дүгнэлт өгөхдөө байнга хэлж байгаа. Ямар

дүгнэлт өгч байна зөвлөмж өгч байна гэхээрээ хяналтын тогтолцооны тэр дунд шатанд байх ёстой. Дотоод аудитын хууль эрх зүйн орчныг эрх зүйн орчныг хуульчилж өгөөч. Энэ хууль эрх хуульчилсан эрх зүйн орчин байхгүй байгаа нь дунд шатад байх тэр хяналт буюу өдөр тутамд хийгдэж байх газар дээрээ хийгдэж байх тэр хяналтын ажилд төлөвшиж өгөхгүй байна энэ нь хууль байхгүйтэй холбоотой юм гэж үзэж байгаа. Тэгээд энэ дүгнэлтээ сүүлийн 3 удаа энэ жилдээ бараг 4 дэх удаадаа Улсын Их Хуралд толилуулаад байгаа юм.

Энийг бас гишүүд их сайн шийдэж өгөх юм Төсвийн байнгын хороон дээр энэ асуудал байнга яригдаж байгаа. Төсвийн байнгын хороо хуулийн төслийг бас оруулж байгаа байх. Тэгээд энэ асуудал дээр би онцгой анхаараач ээ. Үнэхээр төрийн аудитын байгууллага хүч хүрэхгүй байгаа. Хүн хүч нөөц 6618 газар дээр зөвхөн хагас жилийн хугацаан дээр очиж одоо хяналт тавина гэдэг бол өнгөрчихсөн хойно нь очиж хяналт тавина гэдэг бол бас цааш цаашидаа энэ боломжгүй зүйл.

Тийм учраас дотоод хяналтыг хууль эрх зүйн орчинтой болгож өгөөч ээ гэж байгаа. Энэ бол их санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулахад зөрчлийг багасгахад бол том тогтолцооны нэг шинж чанар болно оо гэж үзэж байгаа юм. Хөрөнгө оруулалттай холбоотой дээр манай Хөрөнгө оруулалтын газрын дарга хариулаад өгчих.

Ч.Чимидсүрэн: Сандаг-Очир гишүүний асуултад нэмж тодруулъя. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудал дээр олон жил дамжин хэрэгжиж байгаа энэ асуудлуудын гол суурь шалтгаан бол нэгдүгээрт төсөвлөлтийн шаардлага хангахгүй олон арга хэмжээнүүдийг баталж байна. Тухайлбал 2022 онд нийт баталсан 664 төсөл арга хэмжээ, нийт 402 төсөл арга хэмжээ нь бол төсвийн шаардлага хангахгүй арга хэмжээнүүд

батлагдсан. Энэ төсвийн шаардлага хангахгүйгээс болоод газрын асуудал шийдэгдээгүй. Магадлалын дүгнэлт нь гараагүй гэх мэт шалтгаануудаас болоод дараа онуудад шилжиж хэрэгжих нэг шалтгаан болж байна.

Хоёр дахь шалтгаан нь төсвийн хуваарийг бол олон төсөл арга хэмжээнд маш бага хэмжээгээр тухайн жилд нь хуваарилж байгаагаас шалтгаалаад олон жил дамжин хэрэгжих ийм нөхцөлүүд үүсэж байна гэдэг ийм дүгнэлтүүдийг хийсэн. Өнгөрсөн жилийн Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолоор үнийн өсөлттэй холбоотой гарсан хөрөнгө оруулалтын ажлуудыг шийдвэрлэсэн.

Дахиад Улсын Их Хурлын 72 дугаар тогтоол гарсан. Энэ 72 дугаар тогтоолоор үнийн өсөлтөөс бусад шалтгаанаар төсөвт өртөг нь нэмэгдсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээн дээр аудитын байгууллага дүгнэлт гарга гэдэг ийм тогтоол гарсан. Энэ тогтоолын хүрээнд одоогийн байдлаар Үндэсний аудитын газарт 334 төсөл арга хэмжээ ирчихсэн хянагдаад явж байгаа. Энэ дээр магадлал нь хэр бодитой байна вэ гэдэг үндэслэлүүдийг төсөвт өртөг нь үндэслэлтэй нэмэгдэж байна уу гэдэг дээр нь дүгнэлт гаргаад энэ 7 сарын 10-нд эхний төсөл арга хэмжээнүүдийн дүгнэлт Их Хуралд ирнэ. Тэгээд 2024 оны төсвөөс өмнө үлдсэн төсөл арга хэмжээнүүдийг шийдвэрлэхээр Үндэсний Аудитын газар ажиллаж байна.

Г.Тэмүүлэн: Сангийн яам нэмэлт тайлбар өгөх үү? Ганбат дарга нэг номер.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. 2022 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хөрөнгө оруулалтын төслийг 3 жил хэрэгжиж дуусдаг хуульчилчихсан байгаа. Тэгэхээр 2024 оны төсвийн жилээс эхлээд тэгээд 3 жил ингээд тэнцвэрийн хэмжээгээр тавигдаж эхлээд ингээд хуульчилчихсан. Тэгэхээр өөрөөр хэлбэл өмнөх жил явж байсан нэг амсуулах төдий эхлүүлээд

ингээд олон жил үргэлжилдэг энэ юм бол байхгүй болно оо гэдгийг энд ингэж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Мөн төсөвт өртгийн нэмэгдлийг Улсын Их Хурлын 2022 оны 72 дугаар тогтоолоор аудитын дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа. Энэ хүрээнд нэг 300 гаруй төсөл энэ дээр яригдаж байгаа. Тэгээд Үндэсний аудитын газартайгаа хамтран энэ дээр бол ажиллаж байна. Мөн үнийн өсөлтийг 2023 онд бүрэн шийдвэрлэхээр Улсын Их Хурал батлагдсан. Энэ хүрээндээ 638 төслийн 303.3 тэрбум төгрөг хэргийн асуудал бол яригдаад энэ асуудлыг 2023 онд бүрэн шийдвэрлэгдэхээр ингэж бол ажиллаж байгаа. Мөн төрийн хэмнэлтийн хуульд хэмнэлтийн хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу бол бид яг улсын төсөв дээр ямар хөрөнгө оруулалт нь хэрэгжих вэ? Орон нутгийн төсвөөр ямар хөрөнгө оруулалт нь хэрэгжүүлж чиг үүргийн хувьд нэлээн заагдаад ялгаатай болгочихсон учраас 2024 оны төсвийн жилээс эхлээд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хувьд зураг төсөвгүй болон мөн хэрэгжих боломжгүй төслүүдийг улсын төсөв дээр тусгах ийм боломжгүй болж байгаа юм.

Тэгэхээр ирэх жилээс эхлээд төсвийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нэлээн цэгцэрнэ ээ. Тэгээд мөн 3 жилийн хугацаандаа тэнцүү хэмжээгээр тавигдаад хэрэгжих ийм боломж нь бүрдэнэ. Тэгэхээр өмнө нь явж ирсэн алдаагаа бид нар давтаж нөгөө амсуулах төдий явж олон жил явагдаад тэгээд жил болгон төсөвт өртөг нь нэмэгддэг. Энэ асуудал бол арилж байгаа гэж бидний зүгээс бол үзэж байгаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Аудит 2023 оны сэдвээ батлуулчихсан. Би юу хэлэх гэж байна вэ гэхээр энэ ноднингийн үнийн өсөлтийн зөрөөтэй магадлалууд хийсэн.

Барилгын хөгжлийн төв. Энэн дээр та бүхэн бас нэг хянаж эргээж хяналт тавихгүй бол энэ их дур зоргоороо янз бүрийн үзэмжийн байдлаар төсөвт өртгийг хэд дахин нэмэгдүүлэх хэдэн хувиар нэмэгдүүлэхэд харилцан адилгүй ийм асуудлууд байгаа шүү. Энэ маш нэг эргээж харах асуудал байгаа юм байна лээ. Энэ одоо яг төсөвт өртгийн үнийн зөрөөний өсөлтийг, барилгын материалын өсөлтийг яаж хэрхэн яаж тооцов. Зарим хөрөнгө оруулалтын ажлууд дээр маш өндөр хэмжээгээр 2, 3 дахин хэмжээгээр өсгөчихсөн. Зарим дээр нь болохоор багаар нь өсгөчихсөн. Ийм асуудлууд асар их байгаа юм байна лээ шүү. Энэ нэг хяналт шалгалт хийвэл энэ дээр нэлээн юм гарч зөрчил юм гарах юм байна даа гэж би бол хувьдаа харж байгаа юм.

Тийм учраас энийг бол бас аудит бас цаашидаа анхаарна биз дээ гэж ингээж хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн санал хэллээ. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр 2022 оны төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайланг уншаад үзэхээр зэрэг бас сайн зүйлүүд байгаад байгаа юм. Үнэхээрийн тийм амаргүй цаг үед Засгийн газар энэ хуулийн хэрэгжилтийг хангах талаар нэлээн гайгүй ажилласан юм уу? Төсвийн үндсэн үзүүлэлтүүд нэлээн гайгүй гарсан юм билээ. Орлогын төлөвлөгөөний биелэлт ч тэр. Зарлага санхүүжилт ч тэр. Төсвийн тэнцлийн алдагдлыг 1.3 их наядоор бууруулсан энэ тэр гээд ингээд үнэхээрийн тийм бас боломжтой гайгүй үзүүлэлтүүд байгаад байгаа.

Дээр нь аудитын дүгнэлтийг би бас нэлээн гайгүй хийгдсэн юм байна гэж ингээж харж байгаа. Хэд хэдэн тодруулмаар зүйл байгаад байгаа юм. Бид энэ гадаадын зээл тусламжийн хөрөнгийн

ашиглалт нэлээн өндөр байна. Энийг дагаад өрийн асуудал яригдаад байгаа. Гэтэл бид үндсэн зээлийн хүү үйлчилгээний төлбөртэй холбоотой юмыг яриад ханшийн зөрөөнийхөө асуудал дээр ямарваа нэгэн үнэлэлт дүгнэлт өгөхгүй байгаа явдал нь эргээд энэ гадаадын зээлийн хөрөнгийн өртөгжилтийг өсгөөд байгаа юм биш биз дээ?

2022 оны гадаад өрийн өсөлт түүний 4.4 их наяд нь ханшийн зөрөө болчиход байгаа байхгүй юу. Тэгэхээр энүүнийг ер нь цаашид бид яаж төсөөлж тодорхой судалгаа дүгнэлт хийж байж авч ашигладаг байх юм аа? Зохицуулах ёстой юм бэ? Энэ дээр манай Сангийн яам ч тэр аудитын байгууллага ч гэсэн тэр ямар бодол санаа дүгнэлт байна вэ гэж.

Хоёр дахь зүйл нэгэнт гаднаас авч ашиглах гэж байгаа хөрөнгийг хүү юмыг нь төлөөд байгаа хэр нь ээ харилцахын үлдэгдэл хэлбэрээр байлгаад хүү төлөөд байгаа юм энэ дүгнэлтээр гарч ирээд байгаа юм.

Тийм учраас тэр бүрэн ашиглах цаг хугацаанд нь ашиглах талынхаа асуудлыг ер нь яаж зохицуулах ёстой юм бэ? Хэд хэдэн зүйл дээр ийм тодорхой дурдагдаж гарч ирсэн зүйлүүд байгаад байгаа юм. Энийг ер нь яах ёстой юм гэж.

Гурав дахь зүйл ер нь энэ баялаг бүтээгчдийг дэмждэг зээл, зээлийн хөрөнгө гэдэг юм уу тусгай сангуудын хөрөнгийн эргэлтийн асуудал удааширчихсан, хүндэрчихсэн дээр нь тухайн жилд төлөвлөгдсөн хөрөнгүүд бүрэн гарч өгөхгүй байгаад байгаа ийм зүйлүүд байгаад байна. Энэнээс болоод энэ эдийн засгийн чинь ажилт төдийлөн тэлэлтийнхээ хэлбэр рүү орж өгөхгүй байгаад байгаа ийм зүйл байгаад байх юм. Энийг ер нь яаж зөв эргэлтээр нь төлөвлөсөн хэмжээндээ гаргаж авч явах талаар зохицуулалт юмнуудаа хийх ёстой юм бэ? Энэ дээр бас Сангийн яам нэг

тодорхой хариулт юмнууд өгөх ёстой байх гэж.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл. Ер нь энэ санхүүгийн ажилчид чинь энэ мэдээлэл технологийн давуу тал программ хангамж дээр тулгуурлаад тайлангаа ч гаргахаа байчихсан. Ер нь үндсэндээ дандаа программаар гаргаад байгаа. Энэнээс болоод энэ анхан шатын баримт бүрдүүлэлтийн чинь юм орхигдсон. Энэнээс болоод та нарын яриад байгаа наад том зөрчил юмнууд чинь замаа алдталаа гардаг болчихсон. Тэгэхээр энүүнийгээ ер нь яаж арилгаж энэ санхүүгийнхээ нөхдүүдийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх энэ программ хангамжийг нь буцаагаад тэр анхан шатынх нь бүртгэл хөтлөлт баримт бүрдүүлэлтийнх нь юмтай уях юм гэдэг ийм зохицуулалтынхаа юмыг ер нь яаж хийнэ гэж бодоод байгаа юм бэ? Энэ дээр одоо би Сангийн яамыг ер нь ямар байр суурь байна вэ гэж. Мөн буцаагаад аудитын байгууллага дээр. Танай дээр бол энэ аливаа хяналт шалгалт гэдэг юм уу энэ аудитын үйл ажиллагаа 2 янзаар л гармаар юм шиг байгаа юм.

Нэгдүгээрт тэр та нарын зөрчил гээд нэг учиргүй өндөр тоо хэлээд.

Г.Тэмүүлэн: *Батжаргал гишүүний микрофоныг нэмээд өгье.*

Ж.Батжаргал: *Би өмнө нь ч бас нэг ярьж байсан юм. Энэ манай санхүүгийн хяналт шалгалтын байгууллагууд аудитын байгууллагуудын дүгнэлт юм ороод ирэхээр зэрэг их өндөр тоотой зөрчилтэй юм ороод ирдэг юм. Тэр нь энэ нягтлан бодох бүртгэл хийгээд стандарттай нийцүүлээд шалгалтын явцад асуудлыг нь шийдээд нийцлээ хангачихдаг юмнууд байгаад байдаг. Энийгээ тусдаа илэрхийлдэг тийм стандарт руугаа шилжихгүй бол энэ нэг хэдэн төсвийн эрх захирагч нарыг чинь нэг л их баахан хөрөнгө мөнгө идчихсэн юм шиг нийгэмд ийм ойлголт өгөөд байгаа байхгүй юу.*

Тийм учраас тэр яах аргагүй зөрчил элдэв бусын юм гаргаад тэр төлбөрийн акт тавигдсан юмаа нэг тусдаа илтгэдэг. Цаад тэр шалгалтын явцад баримт бүрдүүлэлт гэдэг юм уу, хөрөнгөд бүртгэн авах гэдэг юм уу энэ зохицуулалтынхаа юмнуудыг тэр нийцэл хангалт гэдгээрээ илэрхийлдэг ийм арай заагтай Стандарт дотоод дүрэм.

Г.Тэмүүлэн: *Аудитын байгууллага Сангийн яам 2 тайлбар өгнө. Аудитын байгууллага түрүүлээд асуултад хариулж байх уу. 3 номер.*

Ц.Наранчимэг: *Батжаргал гишүүний асуултад хариулъя.*

Үндэсний аудитын газар Наранчимэг байна санхүүгийн ажилтнуудтай холбоотой, яг программ хангамжтай холбоотой анхан шатын бүртгэл дутуу бүртгэлээ хөтлөхгүй байгаа, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тайлангаа гаргахгүй байгаа энэ асуудал үнэхээр байна. Бид өмнөх 2021 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж байхад Улсын Их Хурлын гишүүдээс төрийн аудитын байгууллагад өгсөн үүрэг чиглэлийн дагуу энэ жилийн энэ тайлан дээрээ алдаа зөрчил хоёроо тусад нь тайлагнасан. Монгол Улсын ерөнхий аудитор стандартдаа өөрчлөлт оруулж журмаа өөрчилж тусдаа тайлагнадаг болсон байгаа. Жишээлбэл энэ жилийн Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлагналтай холбоотой 6.8 их наяд төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Үүнийг хууль эрх зүйн орчны хүрээнд 6.7 их наяд төгрөгийн 5355 алдааг аудитын явцад залруулж байгууллагуудын санхүүгийн тайланг зөв болгож өгсөн. 88.9 тэрбум төгрөгийн 229 залруулж өгөх боломжгүй алдааг зөвлөмж өгсөн. Ингээд алдаа зөрчил хоёроо тусад нь тайлагнадаг ийм журамтай болсон байгаа. Энэ хэрэгжээд эхэлсэн.

Г.Тэмүүлэн: Сангийн яам асуултад хариулах уу? Нэг номер.

Ж.Ганбат: Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын гадаад зээлийн хувьд бол 2022 оны нийт ханишийн алдагдал 2 их наяд 638.1 тэрбум төгрөг байгаа бол гадаад үнэт цааснаас үүссэн ханишийн алдагдал 1 их наяд 705.6 тэрбум төгрөгийг нийт 4 их наяд 343 тэрбумын ханишийн гарзтайгаар 2022 онд гарсан байгаа. Олон улсын банк санхүүгийн байгууллага түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийг хэрэгжиж байгаа 77 онд төсөл хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийт 1 их наяд 712.3 тэрбум төгрөг авч ашигласнаас төслийн зээлийн ашиглалтад 1 их наяд 296.3 тэрбум төгрөг хөтөлбөрийн зээлийн ашиглалтад 415.9 тэрбум төгрөгийг тус тус шинээр ашигласан байгаа. Мөн Засгийн газрын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж 2022 онд гадаад зээлийн нөгөө Монголын талын хүрээнд гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 693.6 тэрбум төгрөгийг төлсөн. Үүнээс 496.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрт 197.1 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт төлсөн. Ийм байдалтай байгаа. Яах вэ ханишийн хэлбэлзэл яг төсөв талдаа гол хүндрэлүүд гадаад зээлээ ашиглаж гадаад зээлийн хүүгийн төлбөрийн асуудал дээр гол дарамтууд ирж байгаа л даа.

Тэгэхээр энэ дээр бид бол яг энэнтэй уялдуулж ер нь гадаад зээлээр авч хэрэгжиж байгаа төслүүдийн үр ашиг гадаад зээлийг бид яг ямар үр ашигтай төслүүдэд шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх гэдэг ийм бодлогын асуудлуудыг засгийн түвшинд ярьж ингээж анхаарч ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн асуусан.

Сая баялаг бүтээгч иргэдийн хөрөнгө дээр дутуу гараад байгаа асуудлууд гээд тэрэн дээр яах ёстой юм бол хэн тайлбар өгөх вэ?

Та нэмж тодруулах уу? Та асууж болно. Нэмж тодруулах уу? Танд нэмж хэлэх тайлбар байгаа юу байхгүй юу?

Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: 2022 оны төсвийн гүйцэтгэл мөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжуудын гүйцэтгэл, түүнд хийсэн аудитын талаар ярьж байна. Тэгэхлээр мэдээж жил болгон л энэ төсвийн гүйцэтгэл дээр аудит хийж зөрчил илрүүлдэг. Тэгээд энэ өнгөрсөн 2022 оны төсвийн гүйцэтгэл дээр хийсэн энэ алдаа оноонд жишээлбэл хэдэн хүн ямар хариуцлага үүрсэн байдаг юм? Жишээлэх юм бол Засгийн газрын шүүх ажиллагаа ч гэдэг юм уу ингээд л олон зүйлүүдийг ярьдаг гүйцэтгэлд дүгнэлтүүд өгдөг. Сөрөг дүгнэлт өгсөн анхааруулах шаардлага гарсан. Энд үйл ажиллагаанд хэдэн хүн ажлаас чөлөөлөгдсөн, хэдэн хүн тушаал буурсан, хэдэн хүн цалингийн арга хэмжээ авхуулсан гэсэн ийм тоо баримт байна уу гэсэн ийм зүйлийг асуух гэсэн юм.

Нөгөө талаар төсвийн гүйцэтгэлтэй холбоотой сая Ганбат даргын асуудал 2024 оны төсвөөс асуудлууд жигдрээд энэ 3 хуваагаад 3 жилдээ багтаагаад бий болно гэж байна. Нэгэнт ийм шинэчлэл явах гэж байгаатай холбогдуулж 2018, 2019, 2020, 2021, 2022 онуудад эхэлсэн энэ барилгуудыг энэ жил нэг зоригтой тавиад дуусгаад өгөөч. Хөдөөд сургуулиуд 3 ээлжид орчихсон байна.

Тэгэхдээ 2018 онд эхэлсэн. Хөдөөд цэцэрлэг нь багтахгүй гэрт 2019 оноос хойш, 2018 оноос хойш 4, 5 жил, 5, 6 жил цэцэрлэгийн үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн 2018 онд эхэлчихсэн, 2019 онд эхэлчихсэн Соёлын төвүүд байна. Тэгэхээр энэ одоо 2024 оны энэ төсвийн

шинэчлэл хийхээс өмнө энэ жилд нь багтаагаад 2023 онд бол шинэ хөрөнгө оруулалт тавьсангүй.

Тэгэхээр 2024 оны хөрөнгө оруулалт дээр энэ бүх зүйлийг нэг дуусгаж өгч амрааж өгөөч гэсэн ийм санааг илэрхийлэх гэсэн юм. Тийм боломж байна уу гэж асууж байна.

Нөгөөдөх нь 2022 оны 72 дугаар тогтоолоор аудит хийсэн, аудит хийгээд үнийн зөрөөг олгосон 630 орчим тэрбум төгрөг байгаа гэж байна. Одоо хэдийг нь олгочоод байна вэ? Энэ аудитын дүгнэлтэд орж чадаагүй энэ жил дуусах үнийн зөрөөгөө авч чадаагүй барилгууд хаашаа хандах ёстой вэ? Аудитын дүгнэлтийг гаргуулахын тулд Сангийн яаманд хандах ёстой юу, яг ямар байгууллага тэр үнийн зөрөө ханшийн зөрөөтэй холбоотой асуудлаар дүгнэлт гаргуулах боломжтой вэ гэсэн энэ асуултуудыг асууж байна. Мөн 2024 оны төсөвт энэ шинэчлэлт явж хэмнэлтийн хууль бусад хуулиудтай холбоотой болохоос өмнө ер нь улс орны хэмжээнд саяын миний хэлдэг шиг 2018, 2019, 2020, 2021, 2022 онуудад энэ дутуу гүйцэтгэлтэй барилга хэдэн объект байдаг юм оо? Энэний хэдэд нь аудитын дүгнэлт гарсан үйл ажиллагааг нь 2024 онд оруулах ийм боломжтой гэж үзчихээд байгаа юм болоо? Наадмын дараа үндсэндээ 2024 оны төсөв яригдаад явна. Тэгэхээр энд одоо бүгдээрээ орох боломжтой гэсэн байгаа юу, хэдэн хувь нь орохоор байгаа вэ гэсэн ийм асуултуудыг асууя. Тэгээд хариултын дараа тодруулъя гэж ингэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 4 номер аудит.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар, Энхболд Батсуурь гишүүний асуултад хариулъя.

2018, 2019, 2021, 2022 онуудад үргэлжилсэн энэ барилгуудыг дуусгах тал дээр бас мэдээж Засгийн газарт бас

хандаж хэлж байх шиг байна. Аудитын газраас энэ дээр бол хөрөнгө оруулалтын аудитаар сүүлийн 6-11 жил үргэлжилж байгаа барилгууд. Нийтдээ энэ барилгуудын тоог нь гаргасан нийт 29 барилга байгаа. Энэ дээр мөн салбаруудаар нь бас ангилж гаргасан. Боловсролын яаманд харьяалагдах Барилга хот байгуулалт, Эрчим хүч, Зам, тээврийн яамнуудад харьяалагдах байгууллагуудаа гаргаад энэ дээр энэ орхигдсон барилгууд гэж яригдаж байгаа дээр нийтдээ 270-аад тэрбум төгрөгийн хөрөнгийг бол зарцуулчихаад байна. Тэгээд улсын төсвөөр зарцуулсан энэ хөрөнгө үргүй болох эрсдэлтэй байгаа учраас энэ дээр Засгийн газар дээр яаралтай шийдвэр гаргаж ажилла гэдэг ийм албан шаардлагыг өгсөн. Мөн 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа төсөл арга хэмжээнүүд байна.

Ялангуяа боловсролын салбарт сургуулиуд дээр 3 ээлжийн сургалтад орох эрсдэлтэй байгаа өргөтгөл нь болон барилгын ажил нь 80 хувиас дээш хувьтай явчихсан ийм ажлуудыг дуусга гэдэг албан шаардлагыг төсвийн ерөнхийлөн захирагчдад өгсөн. Энэ дээр Засгийн газар дээр нэг анхаарах асуудал салбар хоорондын уялдааг хангах тал дээр анхаармаар байна. Боловсролын сайд аудитын байгууллагатай бүүр зөвлөмжийн дагуу биечлэн уулзаж харьяа байгууллагуудынхаа хүмүүстэй уулзалтыг зохион байгуулсан. Энэ дээр бол Барилгын яамнаас шалтгаалах нэлээд асуудлууд байна. Ялангуяа Барилгын хөгжлийн төв дээрээс магадлалын дүгнэлт гаргах асуудал нэлээд удааширалтай байгаа учраас энэ салбарууд хоорондын уялдааг хангах тал дээр Засгийн газар дээр бол тусгайлан ярилцаж энийг бас шийдэх хэрэгтэй байна гэдэг ийм дүгнэлтийг ярилцсан байгаа.

Төсөвт өртгийн нэмэгдлийн 72 дугаар тогтоолын дагуу хийж байгаа арга хэмжээн дээр бол хаана хандах вэ гэдэг асуултыг асууж байна. Эхлээд

тухайн гүйцэтгэгч маань захиалагч байгууллагадаа хандана тухайн салбарын яамандаа гэсэн үг. Яамандаа хандахаар тухайн төсөл арга хэмжээнүүдийнхээ нэгтгэлийг Сангийн яаманд хүргүүлээд Сангийн яам энэ төсөл арга хэмжээнүүд дээр дүгнэлт гаргуулъя гээд Үндэсний аудитын газарт ирүүлж байгаа. Одоогийн байдлаар 334 төсөл арга хэмжээний материалыг хүлээж аваад дүгнэлт гаргах ажил явагдаж байна.

Тэгэхээр танай аль салбарт холбоотой арга хэмжээ байгаа юм гэдгийг тэр салбарынхаа яаманд хандаад захиалагч нь Сангийн яамаар дамжуулаад манайд дүгнэлт гаргуулахаар ирүүлж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Одоо бол хугацааг нь хаагаагүй байгаа. Ер нь хүлээж авч байгаа. Эцсийн хугацаа бол угаасаа 2024 оны төсвийн төсөлд тусгахаас өмнө энийг амжуулж гаргах, ирүүлэх шаардлагатай гэдэг ийм л шаардлага тавьчхаад явж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Нэг номер Ганбат дарга.

Ж.Ганбат: 2023 онд нийт 1141 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагийн 78 хувь нь энэ 2023 ондоо ашиглалтад орохоороо ингэж батлагдчихсан байгаа. Энэ дагуу юм нь хэрэгжээд явж байгаа. Мөн бид бол яг тантай адилхан ийм бодлого барьж байгаа. бид эхний ээлжид ашиглалтад орох яаралтай дуусах өмнөх жилүүдэд явж байсан эхлүүлсэн төслүүдээ дуусгах ийм бодлогыг нэг номерт барина гэдэг ийм байдлаар ирэх оны төсөв дээр бол гол бодлогоо гаргаад ингэж ажиллаж байгаа. Мөн Үндэсний аудитын газрын хэлтэс дээр Сангийн яаманд бол төсвийн ерөнхийлөн захирагчаас ирээд бид аудитад өгнө.

Энэ хугацааны хувьд бол 8 сарын 15 гэж бүх юм нь ингээд дуусчихсан ингээд ирүүлчихсэн байх ёстой шүү дээ. Энэ дээр хугацаа нь бид дараа жилийн төсвийн төсөл боловсруулаад дуусахаас

өмнө энэ асуудалд итгэчихсэн байх ёстой. Энэ асуудал дээр гол шаардлага нь бол төсөвт өртгийн магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан байх ёстой гэдэг ийм бол шаардлага тавьж байгаа. Энийг нь хангах юм бол Үндэсний аудитын газраас дүгнэлт гараад мэдээлэл нь манайд ирэх юм бол энэ асуудлыг шийдээд явах бүрэн бололцоотой юм гэдэг ийм ийм асуудлыг нэмж хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Батсуурь гишүүнийг нэмж тодруулъя.

Ж.Батсуурь: Сангийн яам 8 сарын 15 гэж байна. Тэгэхлээр аудитад хугацаа хэлэх ёстой. 8 сарын 15-аас өгөөд тэгээд амжихгүй бол манайх магадлалд ороогүй байна гээд Сангийн яам нь авдаггүй, танайхан бол төдний дотор авна гэсэн хугацаагаа хэлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол өгчихсөний дараа манайх магадлалаараа аудит хийж амжихгүй байна гэх юм бол Сангийн яам аудитгүй байна гээд авахгүй, 1 дүгээрт.

Хоёрдугаарт 29 барилга байгууламжийн чинь бараг 5, 6 нь Сүхбаатар аймагт байна. Нөгөө та бүхэн нэг протоколд тэмдэглээд аваач ээ. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум 3 ээлжийн сургуультай болчихлоо. Аль 2018 онд эхэлсэн. Энийг нэг дуусгаж өгөөч ээ. Эрдэнэцагаан сумын цэцэрлэг, Баяндэлгэр сумын Цэцэрлэг гэрт явж байна. Монгол Улсын хамгийн том сумуудын нэг ээ. Баяндэлгэр сумын Соёлын төв энэ асуудлууд дандаа 2018, 2019, 2020 онуудад эхэлсэн. Тэгээд энэ төсвийн шинэчлэл 2024 оноос өмнө, 2024 оны төсөв дээр.

Г.Тэмүүлэн: Батсуурь гишүүнд нэмж микрофон өгье, нэг минут өгье.

Ж.Батсуурь: Сангийн яаманд мэдээж 8 сарын 15 гэхэд бүх юм боогдчихно. Тийм учраас аудит танайх хэд хоногийн хугацаанд баталж өгөх юм. Жишээлэх юм бол 8 сарын 1-нд өгөх юм бол 15 хоногт багтах уу? 8 сарын 10-ны

дотор өгөх ёстой юм уу? Тэгэхгүй одоо 8 сард багтаагаад өгнө гээд танайд 8 сарын 15-ны дотор өгсөн байдаг. Сангийн яам асуудлаа боочихсон байдаг. Танд аудитын дүгнэлт гараагүй байна гэсэн асуудал мэдээж тавина. Тэгэхлээр та бүхэн одоо хамгийн сүүлийн хугацаагаа л хэлэх ёстой л доо. Энэ баримжаагаар ярьж болохгүй.

Г.Тэмүүлэн: Нэмж тайлбар өгөх байхгүй юу. Хугацаан дээр Энхболд дарга 4 номер.

Д.Энхболд: Ер нь бол Үндэсний аудитын газраас төсөвт өртгийн нэмэгдлийн энэ хүсэлтүүдийг 5 сарын 31-нээр уг нь хаачихсан байсан юм. Тэгээд олон төсөл арга хэмжээнүүд, магадлалын дүгнэлт гаргах ажлаас шалтгаалаад хугацаа сунгах асуудлууд тавиад байсан учраас энэний хугацааг сунгаад явж байгаа. Тэгэхээр Ерөнхий аудитортой ярьж байж энэ эцсийн хугацааг нь хэлье. Тэгэхгүй бол бид нар одоогийн байдлаар асуудлаасаа шалтгаалаад үлдчихэж байж магадгүй гэдэг байдлаар хүлээж аваад л явж л байгаа.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: Ганбат дарга 2, 3 тодруулах юмнууд байна. Энэ ер нь манайхны л буруутай юм. Одоо тэгээд яах вэ гэдэг нь бас мэдэгдэхгүй байх. Нөгөө Говь-Алтай аймгийн төв рүү татсан цэвэр усны шугам байгаа шүү дээ. Тэр чинь яг гэрээн дээрээ 51.9 гээд тэгээд зураг нь гэрээ байгуулснаас хойш зургаа дахиад өөрчилсөн байгаа юм. Тэгээд 2 км-ийн илүү гарчихсан. 53.9 болоод. Тэгээд гэрээ байгуулахад яг баталгаажсан зураг байсан уу гээд. Тэгээд тэр нь явцад нь дахиад энэ Барилгын хөгжлийн төв Барилгын яамныхан өөрчилчих ёстой юм байна гээд өөрчлөөд явсан.

Одоо нөгөө компани нь 2 км-ийн мөнгөө би авна гээд ингээд байдаг. Тэр нэг жил хагас 2 жил орчим бараг болж

байгаа юм шиг байна. Хамгийн сүүлд над руу явуулсан нэг имэйл ирсэн байсан. Сингапурын шүүхэд хандахаар боллоо бид нар гэдэг ийм юм ярьж байна. Энийг ер нь яах ёстой юм. Илүү ажлын зөрүү гэж өгөх ёстой юм уу яах ёстой юм? Энийг барилгын яамтай сууж энэ юун дээр яахгүй бол төсвийн гүйцэтгэл юман дээр чинь ер нь яаж явж байна аа? Зарим нэг юман дээр нь энэ бол илүү ажлынх гээд гарын үсэг зураад баталгаажуулчихсан байгаа юм Барилгын яам. Эрчим хүч юман дээр нь тэгсэн мөртөө мөнгөө өгдөггүй. Ингээд хүлээн зөвшөөрдөг мөртөө байгаад байдаг. Төсөвт тэр нь ингээд суудаггүй яваад байдаг юм байна л даа. Энэ эзэмшигч нартай холбоотой юман дээр чинь тэр юмнууд ийм зөрөө мөрөө юмнууд нь хэр яаж явдаг юм бол? Энийг нэг анхаар. Энэ нөгөө дулааны станцууд бас яг ижилхэн байгаа. Миний сонссоноор бол Баянхонгороос бусад аймгуудын дулааны станцын барилгуудын гүйцэтгэл маш хангалтгүй л байна гэсэн. Бас л санхүүгийн асуудал яригдаад. Үнийн өсөлт одоо тэгээд өөр мөнгөө нэмж өг гэдэг юм явдаг. Энэ юмнуудыг ер нь яах вэ? Энийг нэг өнөөдөр яг одоо би хариулт хүсэхгүй байна. Төсөв ярих үеэр энийг нэг тооцооч.

Хоёр дахь юм энэ Аудитын газраас асууя. Энэ дутуу баригдаж байгаа барилгуудаа яах юм бэ? Танайх чинь нийслэлийн аудит, үр дүнгийн аудит, нийцлийн аудит, үр дүнгийн аудит гээд чухам сайн хийгээд байгаа гээд байдаг. Маш олон тендерүүдэд мөнгийг нь авчхаад барилгаа дутуу хаяад алга болчихсон компаниуд байгаа. Худалдан авах ажиллагаагаа бараг нэг газар болохоор захиалагч мэддэг гэдэг. Захиалагч нь болохоор бид мэдэхгүй шүүхэд хандсан худалдан авах ажиллагааны газар цэрэг цагдаагаар явах ёстой гэдэг.

Энэ дээр танайхан дээр гарсан хариу дүгнэлт гэж юм байдаг уу? Миний мэдэхийн манай аймаг дээр л гэхэд 2 байна. Одоо энэ Тэмүүлэн гишүүний яриад

байдаг Архангай дээр байдаг, Булган дээр байдаг, Сэлэнгэд 7, 8 байдаг. Энэ ер нь аймаг болгонд хамгийн багадаа 2-оос 3 байгаа. Дандаа цүнхний компаниудад ингээд тендер өгөөд явуулчихсан, нэг ч тракторгүй, нэг ч хүрзгүй компаниуд. Тэгээд нөгөө очсон бариад явсан ч юмгүй ингээд дутуу хаяад хэдэн төгрөгийг нь аваад алга болчихсон. Хүн нь ч хайгаад олдохгүй зарим компаниуд нь татан буугдчихсан байна гэдэг. Энэ дээр та нарын гаргасан дүгнэлт гэж юм байдаг юм уу. Их л сайн ажиллаад байгаа гээд байгаа.

Г.Тэмүүлэн: Саяын сүүлийн асуултаас нь хариулаад явах уу? Аудит хариулах уу? Саяын тэр дутуу баригдсан барилгуудтай холбоотой дүгнэлт гарсан эсэх, дараа нь дулааны станцтай холбоотой асуудлуудыг Чойжилсүрэн сайд хариулах уу? 4 номер уу?

Д.Энхболд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэг хэрэгжилт хангалтгүй байгаа барилгуудыг бид нар дотор нь ангилсан. Энэ дээр бол гүйцэтгэгчээс шалтгаалсан зохиогчийн болон захиалагчийн хяналтын шалтгаанаас худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанаас шалтгаалсан гэж олон янзаар ангилаад тухайн шийдвэрүүдийг гаргах чиглэлээр болсон гүйцэтгэгчээс шалтгаалсан асуудлуудыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулахаас өөр арга байхгүй. Үндэсний аудитын төрийн аудитын байгууллагын хүрээнд бол мөрдөн шалгах болон тусад нь шийдвэр гаргах ийм боломжгүй учраас хууль хяналтын байгууллагад шилжүүлэх шийдвэрийг л сонгосон байгаа.

Г.Тэмүүлэн: Яг тодорхой асуулт асуугаад байдаг. Сая энэ дутуу баригдсан барилгууд дээр яг та бүхний зүгээс сая гүйцэтгэгчээс хамааралтай саяын тэр хөрөнгө оруулалт, барилга байшин, тэр сургууль, цэцэрлэг байна уу, эмнэлэг байна уу? Тэрэн дээр хэчнээн байгууллага дээр та бүхэн дүгнэлт гаргаад ингээд хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн

байгаа вэ гэдэг асуудал дээр асуугаад байна шүү дээ. Саяын тодорхой аймгуудыг асууж байна. Тэгэхээр хэд нь шүүхэд шилжээд хэд нь юу гэдэг юм. Мөрдөн байцаалт болоод шүүхийнхээ шатандаа явж байгаа тэр талаар мэдээлэл байгаа юу? Байхгүй юу? Та бүхэн хэдийг шилжүүлсэн. Энэ 2017, 2018, 2019 онуудад тавигдсан хөрөнгө оруулалтууд Төсвийн хууль дээр тусгагдсан асуудлууд гүйцэтгэл байхгүй, 0 гүйцэтгэлтэй байгаа асуудлууд байгаа. Санхүүжилтүүдийг нь авчихсан асуудлууд. 4 номер.

Д.Энхболд: Гүйцэтгэгчээс шалтгаална. Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан нийтдээ 59 барилга байгууламж байгаа. Тэгэхээр бид нар хувийн гүйцэтгэгч байгууллагатай нь харьцдаггүй. Тэрийг хяналтыг нь тавьж байгаа захиалагчид нь шууд албан шаардлага өгдөг, хууль хяналтын байгууллагад наад асуудлаа шийд ээ. Танайх захиалагчийн хяналтыг тавьж ажиллаж байгаа байгууллага учраас гээд түүнээс бол манайх шууд л тэр компанитай харьцдаггүй байгаа. Нийтдээ энэ тайлангийн хавсралт дээр гүйцэтгэлээс шалтгаалан ажил нь зогссон нийт 59 компани байгаа. Удааширалтай орхигдсон барилга нийтдээ 29 төсөл арга хэмжээ байгаа. Хавсралт 2 дээр тайлангийн ар талд арга хэмжээ тус бүрээрээ оруулчихсан байгаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн гишүүн та дулааны станцтай холбоотой тайлбар өгөх үү?

Б.Чойжилсүрэн: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Манай яамны захиалгаар хэрэгжиж байгаа баруун аймгийн дулааны станцын төсөл гэж ийм төсөл байгаа. Санхүүжилт нь бол Солонгос улсын Эксим банкны санхүүжилттэй ийм төсөл бий. Энэ төслийн гүйцэтгэл бас зооохон тийм учир дутагдалтай графикаасаа хоцорчихсон явж байгаа, 1 дүгээрт.

Хоёрдугаарт үнийн өсөлтөд нэрвэгдсэн гэдэг ийм зүйлийг гүйцэтгэгч компаниас манай яаманд 2 удаа тавьсан. Бид эхний ээлжид та нар зургаа хийгээд дуусгаадах. Зургаа батлуулсны чинь дараа төсөв магадлал хийлгэнэ. Энэний дараа тэр нэмэгдсэн юм уу жинхэнээсээ нэмэгдсэн юм уу нэмэгдээгүй юм уу гэдгийг нэгдүгээрт тодруулна.

Хоёрдугаарт Улсын Их Хурлаас төсөв дагаж гарсан тогтоолын дагуу улсын төсөв батлагдсантай холбогдсон тогтоол бий. Энэ барилгын хөгжлийн төвөөс гадна Аудитын ерөнхий газрын дүгнэлт гаргуулах ёстой. Хэрвээ төсөвт өртгөөр нэмэгдсэн юм. Энэ процессууд хэрэгжиж дуусаагүй байна. Зургаа дуусга гэдэг шаардлагыг би өнгөрсөн 2022 оны 8 сарын 30-нд Эрчим хүчний сайдаар очсон. Түүнээс хойш 2 удаа, 3 удаа дуудаж уулзсан. Зургаа хурдан авчиръя, төсвөө хурдан авчир гэдэг ийм шаардлагатай байгаад байгаа. Өнөөдрийн байдлаар харамсалтай нь яг дууссан төсөв, дууссан зураг 2 байхгүй.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн нэмж тодруулъя.

Ш.Раднаасэд: Энэ хэдэн яамдуудын дунд энэ олон юм нь салчихаар ингээд балраад байгаа юм л даа. Дунд нь ингээд хамаг ажлууд алга болоод байх юм. Одоо тэр худалдан авах ажиллагаа, тэр байшинтай холбоотой төсвийн хөрөнгө оруулалттай 89 нийтдээ сая 80 барилгын юм яригдаж байна шүү дээ. Дутуу баригдсан, гүйцэтгэгч нь хаяад явсан гээд. Одоо хариуцах эзэн байхгүй наадах чинь. Худалдан авах ажиллагааны газар нь Шадар сайд дээр. Захиалагч нь гээд энд тэндхийн яамдууд дээр тараад оччихсон худалдан авах ажиллагааны хяналт нь Сангийн яаман дээр. Энийгээ боогоод баглаад энэ нь болохгүй байна, энэ нь цагдаад өг, энэ нь тэр хууль хяналтын байгууллагаар нь явуул гэдэг юмыг хийдэг газаргүй болчихсон.

Захиалагч нар нь нөгөө олон юмныхаа дунд оруулаад ингээд орхиод явчихсан. Тэгээд энэ чинь яг энэний л золиос байхгүй юу. Одоо энэ юуг ч гэсэн бас яг тэгж байна шүү дээ. Зээл тусламжийн юм. Мөнгө нь Сангийн яам. Ингээд захиалагч гээд яамдууд дээр тарчихсан. Тэгээд тэнд нэг өөрчлөлт гарахаар ингээд энэ байгууллагаас зөвшөөрөл авна энэ байгууллагаа баталгаажуулна, тэндээс дүгнэлт гаргуулна гээд ингэж сууж байгаад энэ дунд чинь их юм алдагдаад байна. Энэ дунд их үр дүнгүй юмнууд их болж байна. Өөрсдөө ч их алдаа их гаргаж байна энэ дунд. Тэгээд энэ уул нь аудит ийм ийм бодлогын алдаанууд дээр нь эд нар зөвлөгөө өгч байх ёстой байхгүй юу? Тэр зөвлөмжүүд нь ийм юм руу гарч байх ёстой байхгүй юу? Гол юм нь үр дүнгийн аудит гэдэг юм нь тэр лүү явж байх ёстой. Тэгэхэд чинь нэг жижиг сажиг компанийн юу тайлагнаад л тэрийгээ зөв буруу гэж гарын үсэг зураад л янз янзаар өдөр өдөрт нь юмаа солиод л яваад байх юм.

Занданбал дарга тэр юугаа надад яагаад хэлж өгөхгүй байна? Би өөрт чи аваачиж үзүүлээд танилцуулна гэсэн. Ингээд л алга болчихсон. Нөгөө Алтай, Улиастай, эрчим хүчний юм. Тэгээд нэг нэгээр нь ингээд худлаа юм ярихаар би таны өрөөнд ороод танилцуулчихъя гэж худлаа яриад ингээд тойруулаад.

Г.Тэмүүлэн: Занданбат дарга. 4 номер.

Д.Занданбат: Алтайн Улиастай дээр манай дотоод хяналт ажиллаж байгаа. Тэгээд бид нар одоо энэ наадмаас өмнө ямар ч байсан хийнэ. Ажлын энэ төсвийн гүйцэтгэл эд нар хянагдаад явж байгаа учраас дотоод хяналтын дүн гараад ирэхээрээ би танд танилцуулна. Дотроо хийгдээд явж байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл санхүүг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аудитын тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Нэрсийг авъя. Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Хоёрхон санал байгаад байгаа юм.

Нэгдүгээрт энэ төсвийн хөрөнгө оруулалтын асуудалтай холбоотой юмыг бид эрх зүйн орчин талыг нь нэлээн гайгүй болгож чадсан гэж ойлгоод байгаа юм. Дамаан энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө төсөвт суух төсөл арга хэмжээнд тавигдах шалгуур шаардлагыг их тодорхой болгосон. Хамгийн багадаа, урд жилийн төсвийн магадлалтай тийм төсөл арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтад суулгах талаар хийж өгсөн. Ямар ч том төсөвт өртөгтэй байлаа гэсэн 3 жилд багтааж дуусгаж байхаар эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгсөн.

Энүүгээр дамжиж би энийг янз бүрийн яригдаад байгаа юмыг нэг талдаа гарч зөв шийдэгдэх болов уу гэж ингэж ойлгож байна. Одоо бидэнд энэ барилгын хуульдаа оруулах ёстой юм уу хаанаа оруулах ёстой юм нэг зохицуулах ёстой юм байгаад байгаа. Энэ аливаа төсөл арга хэмжээний төсвийн магадлалыг гүйцэтгэж байгаа компани хийлгэдэг байх ёсгүй. Тэр автор захиалагч 2 л хийлгэдэг байх ёстой. Тэгж байж энэ их зөв болно. Сангийн яам гэдэг юм уу энэ байгууллагууд гүйцэтгэгчтэй харьцдаг харьцаа байхгүй. Тэр гүйцэтгэгч зөвхөн захиалагчтайгаа харьцдаг тэр л харьцаанд нь оруулж өгөх ёстой. Ингэж байж энэ асуудал нэг зөв талдаа гарах байх. Тэгээд энэ юм явж шинэ нөхцөл байдлаар эрх зүйн шинэ орчноор явж эхлэх гэж байгаатай холбогдуулаад өмнөх онуудын энэ нэг дутуу дулимаг хийгдсэн гүйцээгүй юмнуудаа бүтэн дуусгах талаар Сангийн яам нэг анхаарлаа хандуулж энэ 2024 оны

төсвийн боловсруулалт төлөвлөгөө талдаа суулгах нь зөв болов уу гэж би нэг ийм зүйлийг хэлмээр байна.

Хоёр дахь зүйл. Энэ гадаадын зээлийн хугацаа, хүү, үйлчилгээний төлбөр юмнууд нь их, бага, бага байгаа. Хугацаа урт гээд бид хэд яриад ашиглаад байх боловч ханишийн зөрүүгөөс болоод өртөг чинь дэндүү өндөр өсөөд болж өгөхгүй байна. Тийм учраас үндэсний тэр хуримтлалынхаа асуудлыг шийдэж тэр хуримтлалаа буцаагаад энэ том төслүүдээ гэдэг юм уу, хөгжлийнхөө асуудалд ашигладаг тийм эрх зүйн орчноо бүрдүүлж явахгүй бол цаашид бид энэ гадаад өр зээлийн асуудлаас хөндийрөхөд гэдэг юм уу дарамтаас гарахад нэлээн төвөгтэй болох нь байна шүү. Тийм учраас ер нь энэ гадаадын зээл тусламжийг дан ганц хугацаа, хүү, үйлчилгээний төлбөр харж авдаг биш ерөөсөө энэ хооронд ханишийн хэлбэлзэл ямар байх вэ гэдэг үнэлэлт дүгнэлтээ хийж байж сая тэр хөрөнгийн үнэ цэн гэдэг юм уу өртөгжилтийн асуудлыг зөв тооцож урьдчилж харж байж авч ашигладаг байдал руугаа шилжихгүй энэ болохгүй нь ээ. Энийг эрх зүйн хувьд нь яаж баталгаажуулах ёстой юм бэ? Энийг би Сангийн яамыг цаашид барих асуудалдаа анхаараарай. Ингээд би энэ гүйцэтгэлээ батламжлах үйл ажиллагааг дэмжиж байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Батжаргал гишүүн бас тодорхой саналуудыг хэлж байна. Сангийн яам болоод аудитын байгууллагынхан сая гишүүдийн хэлсэн асуудлууд анхааруулж тодотгож тавьсан саналуудыг бас судалж үзэж гарц гаргалгаа шийдлүүдийг бас олоорой гэдэг асуудлыг бас анхааруулж хэлэх байна.

Нэгдүгээрт би бас нэг тодорхой зүйлүүдийг бас та бүхэнд хэлье гэж бодоод байгаа юм. Ер нь зүгээр яах вэ нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй

холбогдуулаад нэг алдаа оноо бас нэг яваад байгаа зүйл байгаад байгаа юм. Ер нь аливаа тодотгол болоод гүйцэтгэлийн асуудлууд яригдахад тайлан дээр тухайн тэр юу гэдэг юм тодотгол дээр байна уу тухайн тэр төсөв дээр байна уу ямар нэг тухайн жилийн хугацаанд хийгдсэн зохицуулалтууд хийгдсэн байвал тэрийг бол гүйцэтгэл болоод тайлан дээрээ тодорхой тусгаж оруулж ирэх шалтгаан учруудыг нь тайлбарлах зайлиггүй шаардлагатай байгаа. Хуулийн зохицуулалт нь ч өөрөө бас байгаад байгаа.

Яагаад ийм өөрчлөлт орсон юм. Ямар нөхцөл шалтгааны улмаас хийгдсэн гэдэг юм уу тэр дэлгэрэнгүй тайлбарыг бол тусгах шаардлагатай байгаад байгаа шүү. Та бүхэн нөгөө Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73.2 дахь заалтыг бас нэг анхаарч үзээрэй.

Дараа дараагийн төсвийн гүйцэтгэлүүд орж ирэхэд бол энэн дээр бас энийг анхаарч үзэх ёстой асуудлууд тодорхой дэлгэрэнгүй тусгаж байх ёстой асуудлууд байгаа. Баталчихсан төсвөөс зөрөөтэй бол түүний шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан байна гэсэн зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бол өнгөрсөн жилүүдийн төсвийн гүйцэтгэлүүд дээр бол бас тодорхой тусгагдаж орж ирж байгаагүй нэг ийм хийдэл яваад байгаа гэдгийг та бүхэнд бас хэлэх байна.

Хоёрт бас ерөнхий гүйцэтгэлийг аваад үзэхээр гүйцэтгэл дээр, урсгал зардал дээр нийтдээ нэг зээлийн үйлчилгээний төлбөртэй холбогдуулаад 72.2 тэрбум төгрөг энэ төлөвлөснөөсөө дутуу гүйцэтгэлтэй гарсан байгаад байгаа. Тэгэхээр энэ юуг харуулаад байна вэ гэхээр төлөвлөлт дээрээ бид нар бас нэг талдаа алдаа хийдлээ гаргаад байна. Эсвэл гүйцэтгэл дээрээ цаг хугацаа алддаг юм уу, гэрээ хэлцлүүдийг цаг хугацаанд нь хийхгүй байгаагаас болоод гүйцэтгэл дээр тодорхой хэмжээний дутуу

төлөвлөлтүүд гарч ирж байна гэсэн зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар төлөвлөлт дээр бас нэг талдаа анхаарч ажиллаж оруулж ирэх шаардлагатай байна.

2024 оны төсөв дээр бас тодорхой энэ хийдлүүдийг арилгах ёстой гэсэн энэ саналыг бас хэлэх байна.

Гуравт энэ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг нэгдсэн чуулганаар хэлэлцэж байхад тодорхой бас гишүүд гаргаж ирж тавьж байсан саналууд байсан. Энэ батлагдсан 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулахад төсвийн төлөвлөлтөд өөрчлөлт гарсан байна гэсэн саналуудыг зарим нэг гишүүд хэлж байсан. Энийг бас анхаарч үзээрэй. Батлагдсан төсвийн хүрээ болоод Засгийн газрын төлөвлөсөн 2-ын хооронд зөрүү нь 969.3 тэрбум төгрөг. Батлагдсан гүйцэтгэл 2-ын зөрөө 240 орчим тэрбум төгрөг байна гэсэн асуудлууд байгаа. Хууль зүйн талаасаа ямар нэг зохицуулалтгүй зарлага өссөн тохиолдолд иймэрхүү зохицуулалтгүй харилцаа байгаа бол Хууль зүйн эрх зүйн орч орчин талаас нь бас бид нар анхаарч ажиллах ёстой байгаа. 2024 оны төсөв болоод дагалдсан хуулиудыг оруулж ирэхэд иймэрхүү хийдэлтэй хууль эрх зүйн орчин талаас нь анхаарах ёстой зүйлүүд байгаа бол тодорхой хариуцлагажуулах зүйлүүд байгаа бол та бүхэн бас энэ асуудлуудыг оруулж ирье гэсэн тодорхой саналыг бас эцэст нь хэлж байгаа.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлт гарах ёстой болно. Санал дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулах ёстой. Зарлагын хяналтын дэд хорооны гишүүн Батжаргал дарга танилцуулах уу? Батжаргал гишүүн Зарлагын хяналтын дэд хороонд танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцээж дууслаа.

12.15 цагт

Дараагийн асуудалдаа орцгооё. Ажлын хэсэгт баярлалаа.

Сангийн яамныхан болоод төрийн аудитын байгууллагынханд.

Хоёрдугаар асуудал.

Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээж эхэлье.

Үндэсний аудитын газраас боловсруулж 2023 оны 6 сарын 29-ний өдөр саналаа ирүүлсэн байгаа. Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат дарга танилцуулна. Таныг микрофонд урьж байна. 4 номер.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төрийн аудитын байгууллага нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын харьяа байгууллага.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7 дахь заалтад төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж хуульчилсан нь

төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг баталгаажуулсан юм.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 6 бүлэг, 43 заалт, 225 заалт бүхий Төрийн аудитын тухай хууль 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдөр батлагдаж 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэгт төрийн аудитын байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон онцгой нөхцөлийн төрийн алба хаасан хугацааны зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэрэг нэмэгдлээс бүрдэх бөгөөд хувь хэмжээг Улсын Их Хурал тогтооно гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 31-ний 56 дугаар тогтоолоор төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн баталж 2020 оны эхнээс хэрэгжилтийг ханган Үндэсний аудитын газар, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын албан хаагчдын албан тушаалын цалинг мөрдөн ажиглаж байна.

Улсын Их Хурлаас төрийн аудитын байгууллагын албан тушаалын цалинг тогтоохдоо төрийн аудитын байгууллагын онцлог хараат бусаар ажиглах нөхцөл байдлыг харгалзан тухайн үед мөрдөж байсан АА, ТЗ, ТТ ангиллын зэрэглэлийн цалинтай харьцуулахад 35-аас 41.6 хувиар илүү тогтоож өгсөн байдаг бөгөөд өнөөдрийг хүртэл төрийн аудитын байгууллагын цалингийн сүлжээнд өөрчлөлт ороогүй ээ.

Дээрх хугацаанд Засгийн газрын 2019 оны 72 мөн 2022 оны 488 дугаар тогтоолоор тус тус төрийн захиргааны албан тушаалын цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн байна. Эдгээр өөрчлөлтийн төрийн захиргааны албан тушаалын

цалингийн сүлжээтэй харьцуулахад төрийн аудитын байгууллагын албан тушаалын цалингийн түвшин 15.3 хувиар бага болсон байна. Төрийн аудитын байгууллагад жилд дунджаар 4300 орчим аудит гүйцэтгэж эдгээрт 12 мянга орчим байгууллага хамрагдаж байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт заасан цаглаврын дагуу санхүүгийн аудит зарцуулж буй цаг хугацааг сүүлийн 3 жилийн дунджаар үзэхэд нэг санхүүгийн аудитыг гүйцэтгэхэд 2.2 хүн өдөр зарцуулж байгаа нь хэт богино бөгөөд энэ нь аудитын чанар үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа.

Мөн жилд дунджаар 200 орчим гүйцэтгэл, нийцлийн аудитыг хэрэгжүүлж нэг аудиторт 4.7 аудит ноогдож, нэг аудитад зарцуулах дундаж хугацаа 70 орчим хуанлийн хоног болж байгаа нь гүйцэтгэлийн нэг аудитыг 90-ээс 180 хоногт гүйцэтгэгдэж олон улсын жишигээс 1.3-аас 2.6 дахин богино байгаа юм. 2022 оныг 2019 онтой харьцуулбал төрийн аудитын байгууллагын аудит хийж санал, дүгнэлт өгсөн байгууллага 111-ээр, аудитын байгууллага 4 их наяд 422.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төрийн аудитын үйл ажиллагаа нь нэг төгрөгт ноогдох үр өгөөж 3 дахин өссөн үр дүнтэй байна.

Мөн дэлхий нийтээр 2019 онд Корона вируст халдвар ковид 19 гарсны улмаас эдийн засаг доройтож Монгол Улстай хиллэдэг БНХАУ, ОХУ хилээ хааж хилийн хязгаарлалт удаан хугацаанд үргэлжилснээр гадаад, дотоод худалдаа тасалдах, импортын бараа нийлүүлэлт буурах үнийн өсөлтөөс шалтгаалж инфляцын түвшин сүүлийн 3 жилд байнга өссөөр байна. Эдийн засгийн хүндрэлтэй энэ үед төрийн аудитын байгууллага албан хаагчдын албан тушаалын цалин 2019 онд тогтоосон хэвээр байгаа нь албан хаагчдын хараат бус байх, тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгаа алдагдахад хүрч болзошгүй ээ.

Монгол Улсын төсвийн нийт орлого зардал жил ирэх тусам нэмэгдэж байгаатай уялдан төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитын тоо, ажлын цар хүрээ мөн ихсэж байна. Дээрх нөхцөл байдлуудаас үүдэн Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалинг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоох зайлиггүй шаардлага байна.

Төрийн аудитын байгууллага 2019 оны 56 дугаар тогтоолоор төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоохдоо ҮХЦ, Улсын дээд шүүх, УЕП, ХЭҮК, ТАЗ, СЕХ, СЗХ, ҮСХ, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагуудын ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ болох АА5 зэрэглэлийг суурь болгон тогтоож байсан. Иймд ижил түвшиний дээрх байгууллагуудтай албан хаагчдын албан тушаалын цалинтай дүйцүүлэн төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх саналыг суурь үзүүлэлт болгон тооцов. Эцэслэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Занданбат даргад.

Ингээд та бүхэнд Их Хурлын тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу? Тогтохсүрэн дарга. Тогтохсүрэн дарга байна.

Д.Тогтохсүрэн: Би үг хэлнэ. Яах вэ аудитын байгууллага бол хараат бус байх ёстой. Тийм учраас аудитын байгууллагын цалинг Улсын Их Хурал тогтоож байх нь зөв. Төсвийн гүйцэтгэлд аудит хийдэг учраас Засгийн газраас аль болохоор хараат байх ёстой. Төсвийн асуудал цэвэр Засгийн газрын асуудал байгаа юм. Тийм учраас аудитын

байгууллагын цалинг тогтоох нь би зөв гэж ингээж бодож байгаа юм. 2019 онд ч билүү бид нар нэг тогтоож байсан. Зүгээр нэг л зүйл байгаа юм. Заавал энэ нэг ийм махан тоогоор тавих хэрэг байгаа юм уу үгүй юу? Инфляцын түвшин цаг үеийнхээ нөхцөл байдалтай холбогдоод ингээд нэг өсөөд явдаг нэг итгэцүүртэй ч юм уу ийм хэлбэр рүү оруулахгүй бол ингээд нэг махан тоогоор тавьчихдаг тэгээд л нийгмийн сүлжээнд тавигдсан ч гэсэн нэг их өндөр цалинтай юм шиг харагдаад л нэг ийм юм ингээд харагдаад байдаг юм. Тийм учраас энийг манай Тамгын газар цаашидаа аудитын байгууллага нэг өөр чиглэлээр тавихад нь их анхаарах хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй ингээд нэг л нэг том том тоон дүнгүүд харагдаад л байгаа юм.

Нэгдүгээрт би тийм учраас энэ тогтоолын төслийг дэмжиж байна.

Хоёр дахь нь юу байна вэ гэхээр ер нь аудитын байгууллага төсвийн хуульд оруулах өөрчлөлттэй холбоотой асуудлаараа бодмоор байгаа юм. Энэ төсвийн гүйцэтгэл хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс тавьж байгаа хамгийн гол санал бол танай аудитын байгууллага шалгаад тодорхой дутагдал зөрчлүүдийг илрүүлээд гаргаад ирчихсэн байна. Гэтэл зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцохгүй байна. Нэг албан шаардлага юм уу нэг акт бичээд л ингээд л нэг зөвлөмж өгөөд л орхиод байна. Энэ чинь тодорхой үр дүнд хүрэхгүй байна гээд байгаа юм.

Тийм учраас Төсвийн хууль дээр манай аудитын байгууллага энэ хяналтын дараа авах арга хэмжээтэй холбоотой, нийт төсвийнхөө 10 хувьд нь зөрчил илэрсэн ч гэдэг юм уу 5 хувьд нь зөрчил ирсэн ч гэдэг юм уу ийм тохиолдолд төсвийн шууд захирагч ерөнхийлөн захирагч нар бараг ажлаасаа ингэнэ ингэнэ гэсэн ийм нэг тодорхой хариуцлагын юмнуудыг энэ төсвийн хуультай холбож оруулж ирэхгүй бол жил бүр нэг хэлэлцдэг. Тэгээд нэг баахан

шүүмжлэл өрнүүлдэг. Аудитын байгууллага акт зөрчил нь зөв байна гэдэг. Гэтэл ямар нэг арга хэмжээ авсан юм байхгүй ингээд явчихдаг ийм нэг хариуцлагагүй байдал бий болоод л явчих вий гэж бодож байна.

Тийм учраас аудитын байгууллагыг энэ төсвийн гүйцэтгэлтэй хэлэлцэж байгаатай холбогдуулаад бас нэг ийм санал хэлье ээ гэж бодож байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүн санал хэлчихлээ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Нэрсийг авъя. Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Цалин хөлсний улсын хэмжээний нэгдсэн тийм бодлого тогтолцооны тухай бид яриад байгаа юм. Их Хурал нэг юм тогтоохоороо өөр нэг юм тогтоогоод л. Засгийн газар тогтоохоороо нэг өөр юм тогтоогоод л. Тэгээд л салбаруудын цалингийн ялгамжтай байдлыг бий болгоод л. Ингээд нөхцөл байдлыг нэлээн төвөгтэй болгож байна гэдэг юм яригдаад. Тэгээд сая бид нар чинь энэ цалингийн ялгааныхаа асуудлыг нэг нэлээн томхон хараад зохицуулалтаа хийсэн.

Тэгэхээр зэрэг юу гэж байна гэхээр зэрэг Их Хурлын харьяа байгууллагуудын энэ цалингийн асуудлыг ер нь Их Хурал нэг авч үзээд суурь юмнуудаа их тодорхой болгоод нэгдсэн 1 шийдэл хиймээр байгаа юм. Дан аудитынхыг биш. Одоо тэр Статистикийн хороо гэдэг юм уу, Монголбанк гэдэг юм уу эд нарыгаа бүгдийг нь нэг дор авч үзээд ингээд нэг шийдлээ зөв хийгээд. Тэгээд тэрнээс хойш ер нь үндсэндээ инфляцынхаа түвшинтэй цалинг хөтөлж явах тухай асуудлыг сая бид нар энэ цалингийн шинэчлэлийн асуудал ярихдаа шийдлээ гэж ойлгосон шүү дээ. Тэгээд ер нь тэгээд энэ хэлбэрээрээ цаашид явдаг энэ нөхцөл

байдлыг нь бий болгож өгөх ёстой юм болов уу гэсэн ийм бодолтой байна.

Тэгээд одоо нэгэнт орж ирсэн асуудал учраас энийг дэмжих ёстой гэж. Түрүүн тэр улсууд яриад байгаа юм. Эднийх бол ерөөсөө шалгалт юмнуудаа хийгээд алдаа зөрчил илэрлээ, тэрүүнийг нь тэр төсвийн шууд захирагчийг томилсон эрх бүхий этгээдэд нь тодорхой арга хэмжээ авхуулахаар санал, дүгнэлтээ хүргүүлдэг. Тэгэхээр аудитын байгууллагын тэр шаардлага, зөвлөмж, актын хэрэгжилт бүгд бүртгэлдээ орж түүнийг хэрэгжүүлэх талаар ямар ажил зохион байгуулж ямар үр дүн гарсан талаар буцаагаад эднийд тэр төсвийн захирагч нар мэдээллээ хүргүүлдэг ийм л тогтолцоотой л яваад байгаа.

Тийм учраас энэ тогтолцоогоороо явах нь зөв байх. Харин төсвийн зөрчил юмыг бууруулах гэдэг юм уу хариуцлага юмыг сайжруулах хүрээнд оногдуулах тэр хариуцлагынх нь санцыг нэмэгдүүлэх барих асуудлыг бол хуулиар тусгайлан зохицуулж шийдвэрлэх асуудал нь Их Хурлын онцгой бүрэн эрхэндээ байх юм болов уу гэж ойлгоод байгаа. Харин энэ дээр оруулж ирэх санал, дүгнэлтээ аудитын байгууллага оруулж ирэх юм бол шийдэл нь гарах бололцоо байгаад байгаа.

Би бол энэ л тогтсон юмаараа явах нь зөв. Ер нь аудитын байгууллагын одоогийн явж байгаа энэ арга хэлбэрийг бол би зөв гэж ойлгоод байдаг шүү дээ.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явууля.

Гишүүд анхааралтай байгаарай санал хураалт.

54.5 хувиар дэмжигдсэн байна.

Энэ тогтоолтой холбогдуулаад Тогтохсүрэн даргыг протоколд тусгаад явъя дэмжсэнээр орсон байна төхөөрөмж зөрүү гарсан байна.

Энэ тогтоолыг 23 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх вэ гэсэн энэ горимын саналыг бас гаргаж байна.

7 сарын 1 цалин нь 1 сарын хугацааныхыг олгож байгаа. Төсвийн тодотголоор цалингийн сан нь батлагдсан тогтоол дээр учраас болно. Цалингийн сан дээр бас болно гэсэн саналыг Хууль зүйн яамнаас хэлсэн байгаа. Хууль дээр бол болохгүй байгаа, эргэж үйлчлэх асуудал.

Энүүгээр санал хураачихъя. Энэ тогтоолыг 2003 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн.

Санал хураалт 63.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулах ёстой байгаа.

Батсуурь гишүүн та танилцуулах уу? Батсуурь гишүүн танилцууля.

Ингээд төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

12.31 цагт

Гурав дахь асуудал.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулаарай.

Аудитын байгууллагынханд баярлалаа.

Гурав дахь асуудлыг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасан байгаа. Оролцогчид болон санаачлагчаас асуулт асууж болно. Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Энд нэг санал байгаа юм байна.

12.33 цагт

Дөрөв дэх асуудалдаа орёе.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Тогтохсүрэн даргаас ирүүлсэн нэг санал байна.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр энэ чинь 2 дугаар зүйл дээр юм байна шүү дээ.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Өнөрболор гишүүнээр тасалъя.

Нэгдүгээр зүйл дээр алга байна.

Өнөрболор гишүүн асуулт асууна.

Хуулийн төслийн хоёрдугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Д.Өнөрболор: Энэ өглөөний мэндийг хүргэе гишүүддээ. Тэмүүлэн даргаа ер нь бол энэ асуудал чинь ер нь нэг юмны л 2 тал юм байгаа юм шүү дээ. Ер нь логик агуулгаараа бодоод үзсэн ч, хууль эрх зүйн энэ хэрэгжилт, үр дагавар талаасаа аваад үзсэн ч ерөөсөө л нэг юмны 2 тал асуудал байгаа байхгүй юу. Тэгээд энэ миний ойлгож байгаагаар өнгөрсөн Байнгын хороон дээр бид нар ААН-ийн орлогын татварын тухай хуулийн төсөлтэй хамт энэ Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хууль чинь хуулийн төсөл нь хамтдаа явж байгаа гэж ойлгоод үндсэндээ эрх зүйн дүгнэлт гаргуулах гээд өнгөрсөн Байнгын хороогоор чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 38 дугаар зүйлийн 38.2-оор бүхэлд нь эрх зүйн дүгнэлт гаргахаар ингээд явуулсан байж байгаа гэж ойлгож байгаа.

Тогтохсүрэн даргаас бичгээр ирүүлсэн нэг санал байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл төслийн 2 дугаар зүйлийн 2023 оны 7 дугаар сарын 1-ний гэснийг 2023 оны 8 дугаар сарын 1-ний гэж өөрчлөх. Энэ зарчмын зөрүүтэй саналыг бичгээр гаргасан байна. Энэ саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт 63.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Өнөрболор гишүүн танилцуулна.

Өнөрболор гишүүн танилцуулъя.

Тэгээд эрх зүйн дүгнэлт одоогоор гараагүй байна. Тэгээд энэ дүгнэлтээр Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцээгүй зөрчсөн гэсэн дүгнэлт гарах юм

бол энэ хууль Үндсэн хуулийн зөрчлөө батлагдаад явах юм уу? Би ойлгохгүй байна. Яг ямар эрх ашиг байгаа юм бэ? Дүгнэлт ямар гарахыг яаж хэн урьдчилж ингэж дүгнээд байгаа юм бэ?

Тэгээд ер нь бол би ингээд нэг зүйлийг ингээд хэлэхэд анхнаасаа л энэ анхны хэлэлцүүлэг дээр л Тэмүүлэн дарга миний гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр тодорхой хэмжээний хуулийн төсөл тусгах энэ талаар арга зүйн зөвлөгөөгөөрөө бүрэн ингээд хангаад өнөөдөр хуулийн төслийг бүхэлд нь бас тодорхой хэмжээний санал хураалгачихсан байх юм бол энэ асуудал ингэж даамжрахааргүй нөхцөл байдал үүсэх байсан үүссэн.

Тэгээд ер нь бид нар чинь ингээд ард иргэдэд ямар бэрхшээл учирч байна түүнийг шийдэхийн төлөө энэ төр Улсын Их Хурал, Засгийн газар энэ хууль тогтоомж баталдаг. Тэгэх ч ёстой гэж би ойлгож байгаа шүү дээ. Тэгээд миний санал маш энгийн байгаа байхгүй юу. Ерөөсөө нийслэлд шинээр баригдах 1.5 мвт-ын дулааны эх үүсвэр энэ түүхий нүүрс ашиглахгүй байх асуудал байгаад байгаа юм.

Гэтэл энэ гаалийн тариф энэ Татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Энэ хуулийг өнөөдөр бид нар ингээд хэлэлцээд ингээд явна гээд тэгэхлээр энэ чинь үндсэндээ тийм яг энэ түүхий нүүрсийг үйлдвэрлэх гээд байгаа үйлдвэрлэл бүхий тоног төхөөрөмжүүдийг гаалийн татвараас чөлөөлөх гээд байгаа асуудал болж хувираад байна шүү дээ.

Агуулга л философи энэ хууль эрх зүйн үр дагавар нь хоорондоо яг адилхан салшгүй 2 асуудал байхгүй юу. Тэгээд энэ салшгүй 2 асуудлыг өнөөдөр эрх зүйн дүгнэлт гараагүй байхад чинь энийг нь салгаж ингээд хэлэлцэх гээд байгаа энэ чинь өөрөө хууль бус асуудал биз дээ Тэмүүлэн дарга аа?

Тийм учраас энэ эрх зүйн дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд энэ асуудлыг хойшлуулах шаардлагатай гэж би үзэж байна. Гишүүдийг ч гэсэн дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн тодорхой бас асуудлуудыг хөндөж ярилаа. одоогийн байдлаар энэ 2 хууль бол тусдаа өргөн баригдсан одоо юу гэдэг юм хамт өргөн баригдсан хуулийн төслүүд биш. Нэг нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нөгөөх нь Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тус тусдаа хэлэлцэгдээд ингээд явж байгаа.

Таны нөгөө хууль зүйн дүгнэлт гаргуулах Байнгын хороогоор өнгөрсөн хуралдаанаар дэмжигдсэн санал бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль дээр хууль зүйн дүгнэлт гаргуулах. Энэ санал дэмжигдээд ингээд Улсын Их Хурлын Тамгын газар Хуулийн хэлтэс энэ дээр ажиллаж байгаа гэж би ойлгож байна.

Одоогийн байдлаар ямар нэг эрх зүйн дүгнэлт нь хараахан гар дээр ирээгүй байна. Хэлэлцэх асуудал өнөөдөр хэлэлцэх үед хууль санаачлагчдын зүгээс ямар нэг юу гэдэг юм эрх зүйн зөрчилгүй учраас тодорхой энэ гаалийн тариф болоод Гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцүүлэх горимын саналыг гаргасан. Байнгын хорооны гишүүдийн олонхоороо ингээд дэмжигдээд явсан байгаа. Таны гол оруулах гэсэн заалтын асуудлыг яах вэ бид нар оруулж чадаагүй асуудлыг бол хууль зүйн талаас нь бас танд хэлэх байна.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 40.3.7-д заасны дагуу тухайн нөгөө нэг төсөл хуулийн төслийн заалтын үг өгүүлбэрийн дараа бие даасан агуулга бүхий үг өгүүлбэр нэмэх гэдэг

маань өөрөөр хэлбэл хууль зүйн талаасаа зөрчилтэй болчихоод байна гэсэн саналыг манай хууль зүйн хэлтэс болоод эх барьсан зөвлөхүүд хэлсэн. Энэ үндсэн дээр бид нар энийг бас оруулж болохгүй юм байна гэсэн үндсэн дээр ярьсан.

Хэрэв урьдчилж бичгээр саналаа бид нарт танилцуулж өгсөн бол бид нар бас томъёолол дээр бас дэмжиж туслаад ингээд оруулах боломж бололцоо байсан байх гэдгийг бас хэлэх байна.

Өнөрболор гишүүн нэмж тодруулж асууя.

Д.Өнөрболор: Өнгөрсөн Байнгын хороогоор байна шүү дээ тийм ээ одоо үндсэндээ эрх зүйн дүгнэлтийг гаргана гээд энэ 2 асуудлыг ерөөсөө хамтад нь бид нар хэлэлцээгүй. Эрх зүйн дүгнэлт гаргахаар нийтэд нь бүхэлд нь ингээд шууд явуулсан байж байгаа. Тэгээд өнөөдөр энэ дүгнэлтээр Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцээгүй байна зөрчсөн гэсэн дүгнэлт гаргах юм бол энэ хууль Үндсэн хуулийн зөрчилтэй батлагдаад явах нь ээ Тэмүүлэн дарга аа. Та энэ дээр ямар нэгэн хариуцлага хүлээх нөхцөл байдал үүсэх нь байна шүү дээ.

Нөгөөтэйгүүр энэ таны юу гэдэг юм энэ өмнө нь ч гэсэн болсон, одоогийн ч гэсэн энэ үйлдэл эс үйлдлээрээ ард иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах энэ эрхийн эсрэг үгүй гэж хэлж байгаа энэ нөхцөл байдал чинь дэндүү даамжирлаа шүү.

Энэ асуудал дээр бол манай гишүүд би бас дэмжихгүй. Эрх зүйн дүгнэлт эцэслээд гарсан тохиолдолд энэ асуудал дээр бид нар тийм ээ бас.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн дарга та товч тайлбар хэлчих үү?

Б.Чойжилсүрэн: Өнөрболор гишүүн ээ энэ 2 хууль нэгнийгээ дагаж өргөн баригдаагүй ээ. Тус тусдаа өргөн баригдсан. Бүх хэлэлцүүлгүүдээр энэ 2

хуулийг тус тусад нь хэлэлцсэн. Түрүүчийн Байнгын хорооны хуралдаанаар та Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль дээр Хууль зүйн дүгнэлт гаргая гэдэг таны саналыг би өөрөө дэмжээд ингээд явсан.

Тэгэхээр одоо ингээд бүх юмыг нялзаагаад ийм байдалд баймааргүй байна.

Хоёрдугаарт энэ наадам дөхлөө гэдэг нь наадам дөхөөд хоёр дугаарт энэ хаврын чуулган завсарлага 2 чинь давхацчихаад байгаа болохоос энийг заавал нэг тийм яаран татан юу гаргачихъя гэсэн тийм юм алга. Шаардлагатай бол тэр юу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийнх нь дүгнэлт гарахаар хэлэлцэнэ биз.

Энэ хуулийг нь явуулчихаад гишүүд энийг бас 2 салгаж ойлгооч ээ гэж хүсэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулах уу? Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Би энэ 2 хууль одоо тус тусдаа өргөн баригдсан байж болно. Гэхдээ энэ гарах гэж байгаа үр дагавар эрх зүйн үр дагавар нь угаасаа яг нэг юм. Өөрөөр хэлэх юм бол энэ 2 хууль хоорондоо маш солилцогч холбоотой. Учир нь 1.5 мвт-аас дээш, эрчим хүчний үйлдвэрлэх гэж байгаа энэ үйлдвэрийн тоног төхөөрөмжийг хил гаалиар оруулж ирэхээс чөлөөлөх л асуудал байгаад байгаа юм. Тэгээд энийг түүхий нүүрсээр тийм ээ, нүүрс түлэх тоног төхөөрөмжийг оруулж ирэх үү, эс оруулж ирэх үү л гэдэг асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ бол хоорондоо хамтдаа цуг шийдэгдэх ёстой л ийм л асуудал болчихоод байгаа юм л даа. Энэ агуулгаар нь би хэлж байгаа юм.

Тийм учраас гишүүд энэ дээр бас дэмжиж саналаа хурааж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн санал хэлэх юм байна.

Ж.Батжаргал: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2 хуулийн төсөлд эрчим хүч үйлдвэрлэх эх үүсвэрийн доод хүчин чадлын үзүүлэлтийн тухай л ярьсан. Тэрнээс хаана байгуулах, ямар түши юм хэрэглэж ажиллах барих тухай ерөөсөө 1 ч үг энэ дотор байхгүй ээ.

Тийм учраас энэ би бол ерөөсөө Монгол Улсын энэ 330 сум хөдөө орон нутгийн чинь хөгжил яах аргагүй 1.5 мвт-аас дээш хүчин чадалтай дулааны үйлдвэрлэлийн төвүүд ажиллаж байж энэ нийгэм соёлын байгууллагууд, энэ аж ахуй, бизнесийн байгууллагуудын чинь үйл ажиллагаа нэлээн чанарын хувьд ахих бололцоо боломж нь байгаа юм.

Тийм учраас би энийг дэмжих ёстой гэж ойлгож байгаа.

Улаанбаатар хотод хэрэглүүлэх барих асуудлыг бол тэр тусгайлсан хуулиараа зохицуулалт хийх ёстой. Тэр эрчим хүчний хуульдаа байдаг юм уу, эс үгүй бол энэ Улаанбаатар хотын агаар орчны бохирдлын асуудлаа зохицуулж байгаа хуулиараа л хязгаарлалтаа хийж өгөх ёстой. Энэ чинь улсын хэмжээнд хэрэгжих гэж байгаа арга хэмжээнүүдэд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх үүднээс хуулиуддаа хийж байгаа өөрчлөлт гэж би ингэж ойлгоод байгаа шүү.

Ер нь бол энэ Улаанбаатар хотод түүхий нүүрс ашиглахгүй байх бодлого чиглэл бариад айл өрх 220 мянган гэр хорооллын айл өрхүүдийнхээ түлшний асуудалд ямар шалгуур шаардлага тавих вэ гэдэг юм нь энэ Агаарын бохирдлын

үндэсний хороогоор зохицуулагдаад явчихсан. Нам даралтын зуухнууд буюу энэ жижиг дулаан үйлдвэрлэлийн асуудлууд дээр түлшнийх нь бүтцэд өөрчлөлт хийх ёстой гээд түрүү талаасаа би сайжруулсан түши гэдэг юм уу шахмал түши хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг нь хангасан гэж ингэж ойлгоод байгаа.

Тийм учраас тэр асуудлууд дээрээ нэмэлт тодотголынхоо асуудлыг шийдэх ёстой. Тэрнээс биш энэ улсын хэмжээнд хэрэгжих гэж байгаа юман дээр зөвхөн Улаанбаатарт хэрэглэх гэж байгаа юм шиг ингэж ярьцаагаад энэ асуудлыг гацаагаад баймгүй байна. Би энэ орон нутгийн жижиг суурингууд сумын төвүүдийнхээ хөгжлийн ирээдүйг бодож энэ асуудлыг дэмжиж явж байгаа гэдгээ хэлье.

Г.Тэмүүлэн: Гишүүд суулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн чуулганд танилцуулах хүн байна уу? Батжаргал гишүүн танилцуулъя.

Ингээд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулж Улсын Их Хурлын Тамгын газраас эрх зүйн дүгнэлт нь ирээгүй байгаа учраас энэ асуудлыг хойшлууллаа.

Эрх зүйн дүгнэлт нь гараагүй байгаа учраас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хойшлууллаа.

Ингээд өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх

асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон ажлын хэсэг болоод Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА